

**Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

**5 ханатай, давхар эсгий бүрээстэй, шалтай-40 ширхэг иж бүрэн гэр**

5 ханатай, давхар эсгий бүрээстэй, шалтай нэг гэрийн иж бүрдэлд дараах эд ангиуд багтана.

Үүнд:

№	Барааны нэр	Хэмжих нэгж	1 гэрт байх тоо	Чанар байдал
1	5 ханатай гэрийн мод	ком	1	Гэрийн бүх модыг хатаасан модоор “Монгол гэрийн MNS 0370:2003”, “MNS 0370:2011” стандартын дагуу үйлдвэрлэсэн, чанар, өнгө будаг сайн, барьж тааруулсан, гэрийн модыг иж бүрэн нэг бүрээр нь дугаарлан, унь, ханыг тээвэрлэх нөхцөлийг хангаж багцалж боосон байна.
2	Гэрийн тооно	ш	1	Гэрийн тооныг хорол маягаар дөрвөн ширхэг рамтай модон хадаасаар хадаж хийнэ. Голч нь 1500+-6.5см-ийн өргөнтэй, чагтага уях гархинуудыг бүрэн бэхэлсэн байна.
3	Гэрийн унь	ш	60-65	Хатаасан модоор хийсэн эдэлгээ даах, ижил өнгөтэй, ханын толгой нь тоононы углуургад тохирсон тооны уньтай байхаас гадна нэмэлт 2 уньтай байна. Урт нь 230-235 см байна.
4	Гэрийн багана	ш	2	Баганын тархи, далбааг хооронд нь углуурга нь задлан холболтоор цавуудаж холбосон байна. Баганын өндөр 2350-2500 мм-ийн байна.
5	Гэрийн хана	ш	5	Хананы толгойн тоо 12 /хана бүр/, тур модны урт 2100 мм байна.
6	Эсгий туурга	ш	4	“MNS 5801:2007” стандартын шаардлага хангасан хонины ноосон бор эсгийгээр хийсэн байна.
7	Эсгий дээвэр	ш	2	Унинд тохируулан эсгэж оёсон, 2 талдаа 20-30 см-ээс доошгүй зөрлөгтэй, оосор, бүч оёх гогцоотой байна.
8	Зулхай туурга	ш	4	Зулхайгаар оёсон байна.
9	Зулхай дээвэр	ш	2	Зулхайгаар оёсон байна.
10	Дотуур бүрээс	ш	1	Гэрийн бүх бүрээс нь MNS 0414:2012 стандартын шаардлагад нийцсэн сайн чанарын цуу ямбуугаар гэрт тааруулан оёсон, 2 давхар оёдолтой, 100 см зөрлөгтэй байна.
11	Гадуур бүрээс	ш	1	
12	Хөшиг	ком	1	Хананы урт, өндөр, хаалганы өргөнд тааруулан оосор гогцоог бөхөлж оёсон байна.
13	Гэрийн бүс	ш	5	Хар өнгийн сайн чанарын ременээр гогцоо гарган хийсэн байна.
14	Өрх	ш	1	Ямбуугаар хийж оосор, бүчний гогцоо хадсан байна.
15	Оосор бүч	ком	1	Бөх бат чанартай, даавуун материалаар хийсэн байна. Тоононы чагтага-5, өрхний оосор-4 ш, диаметр нь 1.5 см-ээс багагүй байна.
16	Шал	ком	1	Гэрийн шалыг бүрдүүлэгч хэсэг нь 10-аас цөөнгүй байх ба хэсэг бүрийн модыг тааруулсны дараа баруун урд булангаас эхлэн араб тоогоор дугаарлан, ажлын зургийн дагуу дай модонд хадаж бэхэлнэ.
17	Хаалга	ш	1	Хаалганы самбарын “толь” мод 8-10 мм, хоёр талын шанаавч мод 25 мм-ээс багагүй тус тус зузаантай, 150-155 м өндөртэй, зургаан яс модтой, 2 нугас, 2 бариул, 6 ширхэг гархитай байна.
18	Чанарын баталгаа			1 жил